ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН КОД: СНАГ-2024/17/НА-СТА-ТШЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.


**Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг**
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
**Аудитын менежер: Ц.Хосжаргал**
Утас: 261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
**Ахлах аудитор: В.Эрдэнэцогт**
Утас: 261628 Цахим хаяг: erdenetsogtv@audit.gov.mn
**Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн :Баян ташаагийн эх Аудит ХХК**
**Захирал: Т.Хоролсүрэн**
Утас: 99116028 Цахим хаяг: bte.audit@yahoo.com



Улаанбаатар хот
2024 он

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ..... 2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ..... 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ..... 12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ..... 12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ..... 12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ..... 13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 14
3.5.1 Төсвийн төлөвлөлт ..... 14
3.5.2 Төсвийн гүйцэтгэл ..... 14
3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл ..... 15
4. АУДИТЫН ТАЙЛАН ..... 15
4.1 Ерөнхий зүйл ..... 15
4.2 Материаллаг байдал ..... 16
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 16
4.4 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 16
4.4.1 Завсрын аудитын талаар ..... 16
4.5 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ..... 17
5.1 Төлбөрийн акт ..... 17
5.2 Албан шаардлага ..... 18
5.3 Зөвлөмж ..... 18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ..... 20

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ТБОНӨХБАҮХА | Төрийн болон орон нутгийн өмчөөр хөрөнгө бараа ажил үйлчилгээ худалдан авах |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.02.29 № 07/524

танай ______ -ны № ______ -т

ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ Ж.БАЙГАЛМАА ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний байгууллагаас цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон 298,279.9 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр ба санхүүгийн тайлагналын үнэн зөв иж бүрэн, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- Ерөнхий захирлын 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/94 тоот тушаалыг үндэслэн худалдаж авсан 387,272.2 мянган төгрөгийн оношлуур, Эрүүл мэндийн яамнаас үнэ төлбөргүй хуваарилсан 2,878,351.5 мянган төгрөгийн оношлуур, урвалжийг акталсныг нотлох устгалын акт байхгүй;
- Эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжилсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээ төлбөртэй холбоотой баримтын бүрдэл, шалгуурт тавих дотоод хяналт хангалтгүйгээс 377,767.4 мянган төгрөгийн санхүүжилт хасагдсан;
- Төлөөлөн удирдах зөвлөлд ажиллах олон нийтийн төлөөллийг сонгон шалгаруулаагүйгээс хяналтын тогтолцоо алдагдах эрсдэл үүссэн;

зэрэг нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.4, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2.10, Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4, 17.7, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3, 14 дүгээр зүйлийн 14.8.6 дахь заалтууд болон ЭМДҮЗ-ийн 2022 оны 12 дугаар тогтоолоор баталсан журамтай нийцэхгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд Халдварт өвчин судлалын үндэсний төв нь гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн системд шилжиж Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт авч ажиллаж байна. Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүждэг санхүүжилт нь зөвхөн тусламж үйлчилгээ, эмчилгээний гүйцэтгэлд олгогдож байгаагаас тус төвийн чиг үүргийн зарим хэсэг болох халдварт өвчний урьдчилан сэргийлэлт, тандалт судалгаа, үндэсний хэмжээнд эмчилгээний асуудлыг зохион байгуулахад санхүүжилтийн эх үүсвэр дутагдах эрсдэл ажиглагдаж байна.

**Аудитын гол асуудал**

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн эм боох материалд 2022 онд Эрүүл мэндийн яамнаас үнэ төлбөргүй хуваарилсан хугацаа дууссан 36,695 ширхэг 1,593,156.7 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл бүртгэлтэй байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжилсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төлбөрөөс 1,770,056.1 мянган төгрөг дутуу олгогдсоноос байгууллагын өр төлбөрийн нэмэгдсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 130 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 97.8 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

/Төгрөгөөр/

| код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **106,034,267,847.66** | **102,226,557,842.56** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **13,680,257,788.22** | **9,304,905,399.30** |
| **33** | **АВЛАГА** | **52,574,191.63** | **2,093,933,709.14** |
| 331 | Ажилчидтай холбогдсон авлага | 35,486,144.49 | 3,144,842.08 |
| 332 | Төлбөртэй үйлчилгээний авлага | | 1,770,056,125.92 |
| 335 | Бусад авлага | 17,088,047.14 | 320,732,741.14 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **92,301,435,867.81** | **90,827,718,734.12** |
| 35100 | Түүхий эд материал | 88,747,960,498.16 | 86,989,001,961.90 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 12,566,561,393.15 | 2,420,976,009.67 |
| 35130 | Эм боох материал | 86,181,399,105.01 | 84,568,025,952.23 |
| **35400** | **Хангамжийн материал** | **3,553,475,369.65** | **3,838,716,772.22** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 23,347,949.00 | 30,407,429.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,340,293,293.63 | 1,507,453,588.33 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 104,685,450.00 | 117,004,175.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 18,658,600.80 | 15,640,210.00 |
| 35460 | Хүнсний материал | 34,017,990.00 | 28,669,497.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 2,032,472,086.22 | 2,139,541,872.89 |
| | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **60,028,067,263.92** | **58,032,951,339.69** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **60,028,067,263.92** | **58,032,951,339.69** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **57,216,256,752.29** | **55,276,536,393.02** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 41,536,374,439.19 | 41,718,496,136.19 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -4,687,499,773.74 | -5,996,440,705.14 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 2,359,523,213.85 | 2,711,798,114.85 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -1,150,283,372.98 | -1,247,616,488.85 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 30,791,555,069.08 | 32,792,987,501.35 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -2,865,265,652.74 | -5,876,662,864.04 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 2,179,130,210.54 | 2,098,022,221.51 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -1,045,014,944.84 | -1,068,649,370.42 |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 67,477,309.48 | 67,476,323.48 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | -22,240,032.18 | -27,800,017.50 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 68,108,480.00 | 140,912,280.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -15,608,193.37 | -35,986,738.41 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **2,867,378,411.63** | **2,756,414,946.67** |
| 39301 | Программ хангамж | 140,687,750.00 | 149,629,750.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -15,963,918.37 | -80,301,483.33 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 2,742,654,580.00 | 2,687,086,680.00 |
| | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **166,117,903,011.58** | **160,259,509,182.25** |
| | **НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН** | **65,251,410.99** | **2,519,486,982.33** |
| | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН** | **65,251,410.99** | **2,519,486,982.33** |
| 413 | Өглөг | 54,849,011.00 | 2,519,486,982.33 |
| 4131 | Ажилчидтай холбогдсон өглөг | | 36,077,471.65 |
| 4132 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 31,349,011.00 | 2,480,084,510.69 |
| 4134 | Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг | 23,500,000.00 | |
| **4136** | **Бусад өглөг** | **10,402,399.99** | **3,324,999.99** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 10,402,399.99 | 3,324,999.99 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **166,052,651,600.59** | **157,740,022,199.92** |

| | | | |
|---|---|---|---|
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **166,052,651,600.59** | **157,740,022,199.92** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 20,296,448,769.60 | 20,296,448,769.60 |
| 51100 | Улсын төсвийн хөрөнгө оруулсан | 20,296,448,769.60 | 20,296,448,769.60 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 111,666,449,746.43 | 103,365,255,941.61 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | | 111,677,885,342.28 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | -8,312,629,400.67 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 34,089,753,084.56 | 34,078,317,488.71 |
| | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **166,117,903,011.58** | **160,259,509,182.25** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/Төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | **112,486,344,989.43** | **69,759,001,095.66** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **74,929,976,137.51** | **49,976,468,513.10** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **74,929,976,137.51** | **49,976,468,513.10** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **74,929,976,137.51** | **49,976,468,513.10** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 21,578,326,591.37 | 1,023,093,770.12 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 158,852,685.54 | 23,317,215,623.17 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- ҮХ | 10,008,879,261.34 | 2,692,656,973.21 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- БМ | 43,183,917,599.26 | 22,943,502,146.60 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **37,556,368,851.92** | **19,782,532,582.56** |
| 1330 | Төсвийн захирагчдаас | 10,808,639,434.40 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 8,479,210,830.40 | |
| **131105** | **Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого** | **2,329,428,604.00** | |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 26,747,729,417.52 | 19,782,532,582.56 |
| **134002** | **Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих** | **26,747,729,417.52** | **19,782,532,582.56** |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **59,957,444,031.21** | **51,183,551,899.13** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **59,957,444,031.21** | **51,183,551,899.13** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **59,115,545,701.22** | **50,229,846,653.33** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 23,906,244,830.75 | 22,423,530,340.46 |
| 210101 | Үндсэн цалин | 12,099,272,200.81 | 9,980,849,775.39 |
| 210102 | Нэмэгдэл | 7,569,045,269.00 | 9,177,547,455.47 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 684,362,320.00 | 659,210,044.53 |
| 210104 | Урамшуулал | **3,553,565,040.94** | **2,605,923,065.07** |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **3,030,476,775.69** | **2,898,845,456.96** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,892,273,849.07 | 1,856,485,691.05 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 293,951,515.52 | 216,107,746.67 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 356,559,073.67 | 376,976,966.61 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 70,066,768.53 | 40,391,805.46 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 417,625,568.90 | 408,883,247.17 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **1,309,724,326.62** | **1,794,600,860.59** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 558,894,298.83 | 899,367,697.42 |
| 210302 | Түлш, халаалт | 309,586,790.31 | 443,336,493.15 |



01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАГДМАЛ

| | | | |
|---|---|---|---|
| 210303 | Цэвэр, бохир ус | 441,243,237.48 | 451,896,670.02 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **1,790,558,425.43** | **2,301,414,763.64** |
| 210401 | Бичиг хэрэг | 239,963,541.63 | 140,800,634.70 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 905,853,855.20 | 917,980,954.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 101,001,015.16 | 99,378,351.10 |
| 210404 | Ном, хэвлэл | 28,852,860.00 | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 45,189,210.00 | 62,486,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 246,885,510.50 | 423,812,927.55 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 222,812,432.94 | 656,955,896.29 |
| **2105** | **Нормативт зардал** | **21,156,775,624.13** | **12,448,577,214.96** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 19,747,329,092.13 | 10,886,896,878.21 |
| 210502 | Хоол, хүнс | 1,409,446,532.00 | 1,561,680,336.75 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 446,316,460.00 | 616,564,795.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,850,000.00 | 588,244,000.00 |
| **210604** | **Урсгал засвар** | **443,466,460.00** | **28,320,795.00** |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,121,181,230.00 | 622,021,490.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 51,864,960.00 | |
| **210702** | **Дотоод албан томилолт** | **1,069,316,270.00** | **622,021,490.00** |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,975,608,028.93 | 1,553,651,947.36 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,816,117,393.93 | 1,525,875,169.91 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 7,200,000.00 | 13,000,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 6,450,590.00 | 1,929,555.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 2,775,400.00 | 2,310,211.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 607,728.00 | 495,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 6,840,000.00 | 2,434,061.45 |
| 210807 | Газрын төлбөр | 97,790,792.00 | |
| **210809** | **Улсын мэдээллийн маягт хэвлэх , бэлтгэх** | **37,826,125.00** | **7,607,950.00** |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,378,659,999.67 | 5,570,639,784.36 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 117,989,667.83 | 214,001,750.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 872,500.00 | |
| **210903** | **Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол** | **4,259,797,831.84** | **5,356,638,034.36** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **841,898,329.99** | **953,705,245.80** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 841,898,329.99 | 953,705,245.80 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 620,318,329.99 | 907,392,906.80 |
| **213209** | **Нэг удаагийн тэтгэмж урамшил** | **221,580,000.00** | **46,312,339.00** |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **52,528,900,958.22** | **18,575,449,196.53** |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 39,461,852,886.11 | 26,888,078,597.20 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | | 264,169,107.60 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 39,460,697,886.11 | 26,623,909,489.60 |
| 225011 | Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал | 1,155,000.00 | |
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН | -39,461,852,886.11 | -26,623,909,489.60 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН | 13,067,048,072.11 | -8,312,629,400.67 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/Төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **68,888,720,295.62** | **42,441,951,819.97** |
| **00012** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **68,888,720,295.62** | **42,441,951,819.97** |
| **00120** | **Нийтлэг татварын бус орлого** | **68,886,191,316.37** | **42,441,951,819.97** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **32,582,907,873.51** | **24,429,475,363.33** |
| 120004 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 21,604,913,208.66 | 1,110,472,120.26 |
| 120010 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 10,977,994,664.85 | 23,319,003,243.07 |
| **1220** | **Тусламжийн орлого** | **36,303,283,442.86** | **18,012,476,456.64** |
| 122001 | Хандив тусламж-дотоод | 36,303,283,442.86 | 18,012,476,456.64 |
| **00003** | **Бусад орлого / нэр данс зөрүү** | **2,528,979.25** | **-** |
| 300015 | Нэр данс зөрүү | 2,528,979.25 | - |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **65,056,399,886.40** | **45,939,837,864.37** |
| **00021** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **65,056,399,886.40** | **45,939,837,864.37** |
| **00210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **64,214,154,456.41** | **44,986,132,618.57** |
| **02101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **24,192,486,842.23** | **22,610,038,553.96** |
| 210101 | Үндсэн цалин | 9,094,738,421.15 | 10,440,415,396.35 |
| 210102 | Нэмэгдэл | 10,661,059,077.98 | 9,225,885,824.32 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 888,051,507.00 | 555,198,253.46 |
| 210104 | Урамшуулал | 3,548,637,836.10 | 2,388,539,079.83 |
| **02102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **3,106,064,538.65** | **2,640,530,430.82** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 2,244,757,489.93 | 1,944,186,635.04 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 214,217,408.88 | 180,134,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 177,368,555.80 | 148,315,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 42,704,712.91 | 36,604,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 427,016,371.13 | 331,288,695.78 |
| **02103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **1,308,202,326.62** | **1,794,600,860.59** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 558,894,298.83 | 899,367,697.42 |
| 210302 | Түлш, халаалт | 308,864,790.31 | 443,336,493.15 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 440,443,237.48 | 451,896,670.02 |
| **02104** | **Хангамж, бараа материалын зардал** | **1,472,141,699.19** | **1,347,582,568.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 203,503,691.03 | 151,247,622.70 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 900,334,999.00 | 905,996,853.20 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 113,372,431.16 | 92,629,551.10 |
| 210404 | Ном, хэвлэл | 38,302,860.00 | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 50,704,560.00 | 62,915,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 165,923,158.00 | 134,793,541.00 |
| **02105** | **Нормативт зардал** | **24,015,867,626.43** | **8,914,059,819.16** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 22,409,559,960.43 | 7,309,608,597.91 |
| 210502 | Хоол, хүнс | 1,523,636,366.00 | 1,555,121,121.25 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 82,671,300.00 | 49,330,100.00 |
| **02106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **6,616,769,472.25** | **5,196,108,395.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,041,042,180.25 | 5,109,164,126.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,575,727,292.00 | 86,944,269.00 |
| **02107** | **Томилолт, зочны зардал** | **1,119,722,230.00** | **634,407,000.00** |
| 210701 | Гадаад албан томилолт | 51,864,960.00 | |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,067,857,270.00 | 634,407,000.00 |
| **02108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,199,518,995.21** | **1,627,583,241.04** |



01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,031,275,005.21 | 1,595,029,613.59 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 24,000,000.00 | 13,000,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 6,165,470.00 | 1,929,555.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 2,775,400.00 | 2,310,211.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 607,728.00 | 495,000.00 |
| 210806 | Мэдээлэл технологийн үйлчилгээ | 6,840,000.00 | 7,384,061.45 |
| 210807 | Газрын төлбөр | 97,790,792.00 | |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 30,064,600.00 | 7,434,800.00 |
| **02109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **183,380,725.83** | **221,221,750.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 182,508,225.83 | 221,221,750.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага х | 872,500.00 | |
| **00213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **842,245,429.99** | **953,705,245.80** |
| **02132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **841,898,329.99** | **953,705,245.80** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 620,318,329.99 | 907,392,906.80 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 221,580,000.00 | 46,312,339.00 |
| **02133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **347,100.00** | **-** |
| 261090 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 347,100.00 | - |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **-** | **(3,497,886,044.40)** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **-** | **877,466,344.52** |
| **00022** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **877,466,344.52** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 877,466,344.52 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **(877,466,344.52)** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **3,832,320,409.22** | **(4,375,352,388.92)** |
| 00009 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл / үндсэн | 9,847,937,379.00 | 13,680,257,788.22 |
| **00011** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **13,680,257,788.22** | **9,304,905,399.30** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

/ төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **20,296,448,769.60** | **34,089,753,084.56** | **98,599,401,674.32** | **152,985,603,528.48** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **20,296,448,769.60** | **34,089,753,084.56** | **98,599,401,674.32** | **152,985,603,528.48** |
| Тайлант үеийн үр дүн | | | 13,067,048,072.11 | 13,067,048,072.11 |
| **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **20,296,448,769.60** | **34,089,753,084.56** | **111,666,449,746.43** | **166,052,651,600.59** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 11,435,595.85 | 11,435,595.85 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **20,296,448,769.60** | **34,089,753,084.56** | **111,677,885,342.28** | **166,064,087,196.44** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | (11,435,595.85) | | (11,435,595.85) |
| Тайлант үеийн үр дүн | | | (8,312,629,400.67) | (8,312,629,400.67) |
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **20,296,448,769.60** | **34,078,317,488.71** | **103,365,255,941.61** | **157,740,022,199.92** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **78,482,104,900.00** | **46,817,304,208.89** | **31,664,800,691.11** | **59.7** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **78,482,104,900.00** | **46,817,304,208.89** | **31,664,800,691.11** | **59.7** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **77,654,685,500.00** | **45,863,598,963.09** | **31,791,086,536.91** | **59.1** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **30,018,048,100.00** | **22,610,038,553.96** | **7,408,009,546.04** | **75.3** |
| 210101 | Үндсэн цалин | 14,650,456,100.00 | 10,440,415,396.35 | **4,210,040,703.65** | 71.3 |
| 210102 | Нэмэгдэл | 11,199,303,100.00 | 9,225,885,824.32 | **1,973,417,275.68** | 82.4 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 753,378,700.00 | 555,198,253.46 | **198,180,446.54** | 73.7 |
| 210104 | Урамшуулал | 3,414,910,200.00 | 2,388,539,079.83 | **1,026,371,120.17** | 69.9 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **3,165,517,800.00** | **2,640,530,430.82** | **524,987,369.18** | **83.4** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 2,213,431,700.00 | 1,944,186,635.04 | **269,245,064.96** | 87.8 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 230,831,200.00 | 180,134,700.00 | **50,696,500.00** | 78.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 197,628,200.00 | 148,315,500.00 | **49,312,700.00** | 75.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 47,559,300.00 | 36,604,900.00 | **10,954,400.00** | 77.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 476,067,400.00 | 331,288,695.78 | **144,778,704.22** | 69.6 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **1,894,304,600.00** | **1,794,600,860.59** | **99,703,739.41** | **94.7** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 895,237,000.00 | 899,367,697.42 | **-4,130,697.42** | 100.5 |
| 210302 | Түлш, халаалт | 497,562,300.00 | 443,336,493.15 | **54,225,806.85** | 89.1 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 501,505,300.00 | 451,896,670.02 | **49,608,629.98** | 90.1 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **1,700,343,800.00** | **1,350,791,468.00** | **349,552,332.00** | **79.4** |
| 210401 | Бичиг хэрэг | 191,054,800.00 | 151,247,622.70 | **39,807,177.30** | 79.2 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,162,152,300.00 | 905,996,853.20 | **256,155,446.80** | 78.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 131,480,800.00 | 92,629,551.10 | **38,851,248.90** | 70.5 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 65,000,000.00 | 62,915,000.00 | **2,085,000.00** | 96.8 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 150,655,900.00 | 138,002,441.00 | **12,653,459.00** | 91.6 |
| **2105** | **Нормативт зардал** | **26,091,996,900.00** | **8,914,059,819.16** | **17,177,937,080.84** | **34.2** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 24,095,718,000.00 | 7,309,608,597.91 | **16,786,109,402.09** | **30.3** |
| 210502 | Хоол, хүнс | 1,946,278,900.00 | 1,555,121,121.25 | **391,157,778.75** | **79.9** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 50,000,000.00 | 49,330,100.00 | **669,900.00** | **98.7** |



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **9,751,754,800.00** | **6,070,365,839.52** | **3,681,388,960.48** | **62.2** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 9,555,254,800.00 | 5,862,889,678.52 | **3,692,365,121.48** | **61.4** |
| 210604 | Урсгал засвар | 196,500,000.00 | 207,476,161.00 | **-10,976,161.00** | **105.6** |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **1,759,373,100.00** | **634,407,000.00** | **1,124,966,100.00** | **36.1** |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,759,373,100.00 | 634,407,000.00 | **1,124,966,100.00** | **36.1** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,935,258,800.00** | **1,627,583,241.04** | **307,675,558.96** | **84.1** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,844,760,800.00 | 1,595,029,613.59 | 249,731,186.41 | **86.5** |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 15,840,000.00 | 13,000,000.00 | 2,840,000.00 | 82.1 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,400,000.00 | 1,929,555.00 | 470,445.00 | 80.4 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 2,400,000.00 | 2,310,211.00 | 89,789.00 | 96.3 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 850,000.00 | 495,000.00 | 355,000.00 | 58.2 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 8,208,000.00 | 7,384,061.45 | 823,938.55 | 90.0 |
| 210807 | Газрын төлбөр | 47,800,000.00 | 0 | 47,800,000.00 | 0.0 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 13,000,000.00 | 7,434,800.00 | 5,565,200.00 | 57.2 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,338,087,600.00** | **221,221,750.00** | **1,116,865,850.00** | **16.5** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,338,087,600.00 | 221,221,750.00 | 1,116,865,850.00 | 16.5 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **827,419,400.00** | **953,705,245.80** | **-126,285,845.80** | **115.3** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **827,419,400.00** | **953,705,245.80** | **-126,285,845.80** | **115.3** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 767,419,400.00 | 907,392,906.80 | -139,973,506.80 | 118.2 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 60,000,000.00 | 46,312,339.00 | **13,687,661.00** | **77.2** |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **78,482,104,900.00** | **42,441,959,730.06** | **36,040,145,169.94** | **54.1** |
| **33** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **20,594,407,900.00** | **18,012,476,456.64** | **2,581,931,443.36** | **87.5** |
| 330002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 20,594,407,900.00 | 18,012,476,456.64 | **2,581,931,443.36** | **87.5** |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **57,887,697,000.00** | **24,429,483,273.42** | **33,458,213,726.58** | **42.2** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,464,800,000.00 | 1,110,472,120.26 | **3,354,327,879.74** | **24.9** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 53,422,897,000.00 | 23,319,003,243.07 | 30,103,893,756.93 | **43.6** |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 13,680,257,788.22 | | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 9,304,905,399.30 | | |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1** | **1** | - | **100.0** |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | - | **100.0** |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **750** | **712** | 38 | 94.9 |
| 620001 | Удирдах ажилтан | 58 | 58 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 443 | 429 | 14 | 96.8 |
| 620003 | Үйлчилгээний ажилтан | 163 | 139 | 24 | 85.3 |
| 620003 | Дэмжих үйлчилгээний ажилтан | 70 | 70 | - | 100.0 |
| 620004 | Гэрээт ажилтан | 16 | 16 | - | 100.0 |



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01 ХЯЗГААРЛАГДМАЛ

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Халдварт өвчин судлалын үндэсний төв нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо "Олон улсын эрүүл мэндийн дүрэм, Халдварт өвчинтэй тэмцэх Ази Номхон далайн бүсийн стратегийн шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан Шинжлэх ухаан технологийн дэвшил, хүний нөөцийн тогтвортой хөгжлийг дэмжигч байгууллага байна" гэж тодорхойлсон байна.

Халдварт өвчин судлалын үндэсний төв дараах зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Тус байгууллага нь халдварт өвчний хяналт,урьдчилан сэргийлэлт, тандалт судалгаа оношилгоо, эмчилгээний асуудлыг үндэсний хэмжээнд удирдан зохион байгуулах мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;
- Нэгдсэн Үндэстний Байгууллагын тогтвортой хөгжлийн зорилт, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эрүүл мэндийг дэмжих, хамгаалах зорилго, зорилт болон "Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого"-ын хэрэгжилтийг хангах;
- Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгон хүн амыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тандах, хариу арга хэмжээ авах;
- Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд шинэ технологи нэвтрүүлэх, нутагшуулах;
- Анхан болон лавлагаа шатлалын эмнэлгүүдийг мэргэжил зүйгээр хангах, дэмжлэгт хяналт хийх;

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Халдварт өвчин судлалын үндэсний төв үйл ажиллагаандаа Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бусад хууль, тогтоомжийг мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний 240,241 тоот тогтоол "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай";
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 28-ны 08 тоот тогтоол "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай";
- Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол "Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай"
- ЭМДҮЗ-ийн 12 дугаар тогтоол "Журам шинэчлэн батлах тухай"

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй гэж үзсэн болно.

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Ерөнхий захирлын 2022 оны А/2 тоот тушаалаар "Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дотоод хяналт шалгалтын журам" батлан мөрдөж дотоод аудитын ажлын төлөвлөгөөг баталж, хяналт шалгалт хийгдэж байна.

Дотоод аудит, аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Халдварт өвчин судлалын  үндэсний төв нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.
Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Халдварт өвчин судлалын  үндэсний төв нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн ба тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,858,393.8 мянган төгрөгөөр буюу 3.6 хувиар буурсан  байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 13,680,257.8 | 9,304,905.4 | (4,375,352.4) |
| Авлага | 52,574.2 | 2,093,933.7 | 2,041,359.5 |
| Бараа материал | 92,301,435.9 | 90,827,718.7 | (1,473,717.1) |
| Үндсэн хөрөнгө | 60,083,635.2 | 58,032,951.3 | (2,050,683.8) |
| **Нийт хөрөнгө** | **166,117,903.0** | **160,259,509.2** | **(5,858,393.8)** |
| Өр төлбөр | 65,251.4 | 2,519,487.0 | 2,454,235.6 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 166,052,651.6 | 157,740,022.2 | (8,312,629.4) |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **166,117,903.0** | **160,259,509.2** | **(5,858,393.8)** |

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 9,304,905.4 мянган төгрөг болж 4,375,352.4 мянган төгрөгөөр буурсан нь эмнэлэг, тусламжийн үйлчилгээний орлого болон туслах үйл ажиллагааны орлого төлөвлөснөөс буурсан эхний үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэлд Эрүүл мэндийн даатгалын сангаас авах  1,770,056.1  мянган төгрөг, импортоор авах эмийн 320,732.7 мянган төгрөг, Нийгмийн даатгалын байгууллагаас авах НДШ-н авлага 3,144.8  мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байна.

Бараа материал  худалдан авсан 15,926,028.8 мянган төгрөг, Эрүүл мэндийн яамнаас үнэ төлбөргүй шилжүүлсэн эм, эмнэлгийн хэрэгсэл 22,082,595.4 мянган төгрөг, бусад байгууллагаас хандиваар  авсан  эм 860,906.7 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, зарцуулсан  зарцуулсан 14,271,203.3 мянган төгрөг, эмнэлгийн байгууллагуудад шилжүүлсэн эм, эмнэлгийн хэрэгсэл болон хангамжийн материал 25,512,258.4 мянган төгрөг, акталж устгасан эм, эмнэлгийн хэрэгсэл 95,185.2 мянган төгрөг болон бусад акталсан хангамжийн материал 464,602.3 мянган төгрөгөөр тус тус хасагдсан байна.



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛА
01 ХЯЗГААРЛАГДМАЛ

Бараа материалын үлдэгдэлд вакцины зориулалттай 69,348,155.3 мянган төгрөг, ороох боох зориулалттай 99,248.5 мянган төгрөг, ариутгалын зориулалттай 44,426.9 мянган төгрөг, багаж жижиг хэрэгслийн зориулалттай 1,047,870.1 мянган төгрөг, оношлуурын зориулалттай 4,855,781.3 мянган төгрөг, эм, тарианы зориулалттай 9,172,544.0 мянган төгрөг зэрэг нийт 84,568,026.1 мянган төгрөгийн эм эмнэлгийн хэрэгслийн 3 сарын нөөц байна. Үүнээс 1,583,156.7 мянган төгрөгийн үнэ бүхий эм, эмнэлгийн хэрэгсэл нь ашиглалтын хугацаа дууссан байна.

Үндсэн хөрөнгө тайлант онд Эрүүл мэндийн яамнаас үнэ төлбөргүй шилжиж ирсэн хөрөнгө 1,959,782.5 мянган төгрөг, гадаадын болон дотоодын аж ахуй нэгж байгууллагаас үнэ төлбөргүй шилжиж ирсэн хөрөнгө 732,874.4 мянган төгрөг, худалдан авсан 877,466.3 мянган төгрөг, ТӨБЗГ-ын 2023 оны 604 дүгээр тогтоолын дагуу балансаас балансад шилжүүлсэн 260,370.1 мянган төгрөг, ТӨБЗГ-ын 2023 оны 686 дугаар тогтоолыг үндэслэн ашиглах боломжгүй болсон акталсан хөрөнгө 666,325.1 мянган төгрөгийн хөрөнгөөр тус тус хасагдсан байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэлд эм ханган нийлүүлэх байгууллагад өгөх өглөг 2,483,409.4 мянган төгрөг, татварын өглөг 31,458.1 мянган төгрөг, Үйлдвэрчний эвлэлийн холбооны татварын өглөг 4,619.4 мянган төгрөгөөр тус тус бүртгэлтэй байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 157,740,022.2 мянган төгрөг болж 8,312,629.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үйл ажиллагааны нийт үр дүнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын сангаас 36,357,201.2 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 16,000,162.3 мянган төгрөг, нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрт 52,357,363.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас урсгал зардлыг бууруулж 6,735,439.0 мянган төгрөгөөр бууруулж, нийт зардлыг 45,621,924.5 мянган төгрөгөөр, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг ЭМДС-аас 41,602,080.5 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 4,019,844,0 мянган төгрөг бүрдүүлэхээр баталжээ.

Тодотголоор нийт зарлагыг 32,860,180.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 78,482,104.9 мянган төгрөгөөр тодотгожээ.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхэд эрүүл мэндийн даатгалын сангаас 20,594,407.9 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 4,464,800.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 53,422,897.0 мянган төгрөг тус тус бүрдүүлэхээр байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 18,012,476.5 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлогоос 24,429,475.4 мянган төгрөг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардал 46,817,304.2 мянган төгрөг буюу 59.7 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь резидент эмч нарын цалинг гүйцэтгэлээр олгохоор төлөвлөснөөс 27,400,518.4 мянган төгрөгөөр дутуу цалингийн санхүүжилт Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс хуваарилагдсан, норматив зардлыг 7,568,567.8 мянган төгрөгөөр ,цалин нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 390,084.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэж, харин эд хогшил, урсгал засварын зардлыг 4,978,765.8 мянган

төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 1,180,192.8 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлуудыг 953,705.8 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 806,484.7 мянган төгрөг, дотоод албан томилолт зардлыг 624,486.6 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 389,175.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 221,221.7 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулагдсан байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/мянган төгрөгөөр/*

| Д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | **71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ** | **78,482,104.9** | **46,817,304.2** | **31,664,800.7** | **59.7** |
| 1.1 | 80101 -Үндсэн үйл ажиллагааны зардал | 24,905,429.7 | 24,642,907.3 | 262,522.4 | 98.9 |
| 1.2 | 80802- Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 60,000.0 | 46,312.3 | 13,687.7 | 77.2 |
| 1.4 | 83601-Нэмэлт Олон улсын байгууллагаас олгосон санхүүжилт | 8,596,101.6 | 4,608,029.4 | 3,988,072.2 | 53.6 |
| 1.5 | 83603-Нэмэлт Дээд шатны төсвөөс хуваарилсан | 44,920,573.6 | 17,520,055.2 | 27,400,518.4 | 39.0 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 30,493,993.2 мянган төгрөгийн 38 бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөж, баталсан байна. Үүнээс 29,304,069.3 мянган төгрөгийн 13 бараа, ажил, үйлчилгээг нээлттэй тендер шалгаруулалтаар, 589,923.9 мянган төгрөгийн 10 араа, ажил, үйлчилгээг харьцуулалтын аргаар, 600,000.0 мянган төгрөгийн 15 бараа, ажил, үйлчилгээг шууд худалдан авахаар төлөвлөгөөнд тусгажээ.

Тайлант онд Эм эмнэлгийн хэрэгсэл 9,398,137.1 мянган төгрөг, тоног төхөөрөмж, хангамж, аж ахуйн материал 5,974,368.1 мянган төгрөг нийт 15,372,505.2 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн ба үүнээс нээлттэй тендер шалгаруулалтаар 11,980,505.2 мянган төгрөгийн бараа, ажил, харьцуулалтын аргаар 2,832,942.9, мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээ, цахим дэлгүүрээс 559,035.1 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэтгэцийн эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.



01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Аудитыг Баян ташаагийн эх Аудитын ахлах аудитор Б.Хандсүрэн, аудитор Б.Уранбилэг, аудиторын туслах Д.Балжирдорж нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Т.Хоролсүрэн чанарын хяналтын менежер Ч.Чимгээ нар гүйцэтгэв.

Халдварт өвчин судлалын үндэсний төв 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян ташаагийн эх Аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 1-1/55 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 112,486,344.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 1,124,863.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн

### 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.3.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд Төсвийн шууд захирагчийн мэдээлбэл зохих нийт 94 мэдээллээс 89 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 5 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай нийцэхгүй, аудитын үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

> <u>*Шийдвэрлэсэн нь*</u>: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь, иж бүрэн, ил тод байршуулж ажиллах зөвлөмж өгөх.

### 4.4 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.4.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, авлага, өглөг, мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, цалин, орлогын дансдын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуууллаа. Завсрын аудитаар 15,109,787.3 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгсөн зөрчлийг арилгасан байна.

### 4.4.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгсөн 221,554.6 мянган төгрөгийн 3 зөвлөмж, 1,362,547.1 мянган төгрөгийн 2 албан шаардлагын биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100.0 хувийн биелэлттэй байна.

*Хүснэгт 3. Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 2 | 1,362,547.1 | 2 | 1,362,547.1 | 100.0 |
| Зөвлөмж | 3 | 221,554.6 | 3 | 221,554.6 | 100.0 |
| **Нийт дүн** | **5** | **1,584,101.7** | **5** | **1,554,101.7** | **100.0** |

### 4.5 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах дараах асуудлууд байна. Үүнд:

- Эрүүл мэндийн яамнаас 2022 онд үнэ төлбөргүй шилжүүлсэн 36695 ширхэг 1,593,156.7 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийн ашиглалтын хугацаа дууссан
- Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/362 тоот тушаалаар эрх шилжүүлсэн 10,100,000.0 мянган төгрөгийн он дамжин хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийн үлдэгдэл 9,301,395.9 төгрөгийн зарцуулалтыг шалгах.
- Худалдан авах үйл ажиллагаатай холбоотой эм, эмнэлэгийн хэрэгслийн 7,207,090.1 мянган төгрөг, хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх 1,108,696.8 мянган төгрөгийн худалдан авалтын гэрээ он дамжин хэрэгжиж байгаа тул гэрээний биелэлтийг шалгах.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,270,573.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 4,950.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 3,265,623.7 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 2 зөрчилд алдааг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй нийт 3,270,573.8 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалтай” дүгнэлт өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Тайлант жилд Меджей ХХК-аас худалдан авах гэрээний дагуу нэг бүрийн үнэ нь 195.0 мянган төгрөгийн үнэтэй 400 ширхэг цээжний шингэн цуглуулах сав авахаас 165 ширхэг савыг гэрээний үнээс илүү үнээр буюу нэгжийн үнийг 225.0 мянган төгрөгөөр тус байгууллагад 4,950.0 мянган төгрөгийг илүү төлсөн байна.
Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6."Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна"; Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа материал худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2.10. гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан баримт бичиг " гэж заасантай нийцэхгүй байна

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зөрчилд төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.


ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 5.2 Албан шаардлага

1. Бараа материалын дансанд Ковидоос бусад халдварт өвчнийг оношлох 2018-2019 онд худалдаж авсан оношлуурыг Ковидын улмаас 2021 оны 7 дугаар сар хүртэл амбулаториор өвчтөнүүдийг хүлээн авч үзлэг хийгээгүйгээс 387,272.2 мянган төгрөгийн ашиглалтын хугацаа дууссан, Эрүүл мэндийн яамнаас 2021-2022 онд үнэ төлбөргүй шилжүүлсэн 2,878,351.5 мянган төгрөгийн хугацаа дууссан оношлуур нийт 3,265,623.8 мянган төгрөгийн оношлуур урвалжийг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Ерөнхий захирлын 2023 оны 5 дугаар сарын 5 өдрийн А/94 тоот тушаалаар өмч хамгаалах байнгын комиссын протокол үйлдээгүй, санхүүгийн албанд мэдэгдээгүй, устгалтын компанитай гэрээ хэлцэл хийлгүйгээр ажлын бус өдөр устгалтыг хийсэн байна. Мөн байгууллагын санхүүгийн албанд устгалт хийсэн бичиг баримт, өмч хамгаалах зөвлөлийн протокол, устгал хийсэн компанитай хийсэн гэрээг устгал хийснээс 10 хоногийн дараа нөхөн бүрдүүлж өгсөн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", 67.2-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна", Төсвийн тухай хуулийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Эм эмнэлгийн хэрэгслийг устгахдаа устгалын компанитай гэрээ хийгээгүй, өмч хамгаалах комиссын хурлын шийдвэр, устгал хийсэн акт зэрэг цаг тухайд нь үйлдээгүй, нөхөн үйлдсэн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэн, хууль хяналтын байгууллагад шилжүүлэх

2. Төлөөлөн удирдах зөвлөлд ажиллах олон нийтийн төлөөллийг сонгон шалгаруулаагүйгээс хяналтын тогтолцоо алдагдах эрсдэл үүссэн. Энэ нь Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4-т "Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, энэ хуулийн 16.10-т заасан суман дахь нэгдсэн эмнэлгээс бусад нэгдсэн эмнэлгийн удирдлагыг эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөл, түүнээс томилсон гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлнэ", 17.7-д "Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөл нь өмчлөгчийг төлөөлөх гурван гишүүн, тухайн эмнэлгийн хамт олныг төлөөлөх гурван гишүүн, олон нийтийг төлөөлөх гурван гишүүнтэй байна" гэж заасантай нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг хуралдуулж олон нийтийн төлөөллийг томилуулах, ТУЗ-ийн чиг үүргээ хэрэгжүүлэх албан шаардлага хүргүүлэх.

## 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

*<u>1.1 Илрүүлэлт:</u>*

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй 7,517,263.7 мянган төгрөгийн хөрөнгийг цаашид ашиглах хугацааг шинэчлэн тогтоох талаар холбогдох арга хэмжээ авч ажиллаагүй байна. Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэн заалтыг тус тус зөрчиж, Үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*1.2 Өгсөн зөвлөмж:*
Элэгдлээрээ өртгөө нөхсөн, цаашид ашиглагдахаар бол үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн ТӨБЗГ-т хүргүүлэн шийдвэрлүүлэх.

*2.1 Илрүүлэлт:*
Эрүүл мэндийн даатгалын сангаас 20,120,299.9 мянган төгрөгийн нэхэмжилснээс 19,782,532.6 мянган төгрөгийн санхүүжилт авч хяналтаар 377,767.4 мянган төгрөгийн санхүүжилт хасагдсан байна. ЭМДС-с авах эмнэлгийн тусламж, үйлчилгээний нэхэмжлэхийн баримтын бүрдүүлэлтэд тавих хяналт хангалтгүйгээс гүйцэтгэлийн санхүүжилтээ бүрэн авч чадаагүй байна. Энэ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3-т "даатгуулагчийг төлөөлж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай тусламж, үйлчилгээний зардлын төлбөр тооцоо хийх гэрээ байгуулах, гэрээний биелэлтэд хяналт тавих, дүгнэх" ; 14 дүгээр зүйлийн 14.8.6.эрүүл мэндийн даатгалтай холбогдсон асуудлаар өөрийн бүрэн эрхийн хүрээнд холбогдох журам, тогтоол, зөвлөмж гаргах; 14.8.7."даатгалын гэрээний дагуу худалдан авсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын болон төлбөрийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг олон улсын эмнэл зүйн удирдамж ашиглан батлах, ЭМДҮЗ-ийн 2022 оны 12 дугаар тогтоол "Журам шинэчлэн батлах тухай " тус тус мөрдөж ажиллаагүй нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*2.2 Өгсөн зөвлөмж:*
Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэхэмжлэхийн баримтын бүрдүүлэлт болон шалгуурт хяналт тавих албан тушаалтнуудыг хариуцлагажуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 9 дүгээр сарын 02 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс: Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй 7,517,263.7 мянган төгрөгийн хөрөнгийг цаашид ашиглах хугацааг шинэчлэн тогтоох талаар холбогдох арга хэмжээ авч ажиллаагүй байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Эрүүл мэндийн даатгалын сангаас 20,120,299.9 мянган төгрөгийн нэхэмжилснээс 19,782,532.6 мянган төгрөгийн санхүүжилт авч хяналтаар 377,767.4 мянган төгрөгийн санхүүжилт дутуу авсан байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Меджей ХХК-иас 400 ширхэг нэг бүрийг 195.0 мянган төгрөгөөр нийлүүлэх гэрээтэй цэвжний шингэн цуглуулах 165 ширхэг савыг гэрээний үнээс дээгүүр үнээр буюу нэгжийн үнийг 225.0 мянган төгрөгөөр нийлүүлсэн байна. | 1 | 4,950.0 | 1 | 4,950.0 | | | | | | | | |
| Бараа материалын дансанд Ковидоос бусад халдварт өвчнийг оношлох 2018-2019 онд худалдаж авсан оношлуурыг Ковидын улмаас 2021 оны 7 дугаар сар хүртэл амбулаториор өвчтөнүүдийг хүлээн авч үзлэг хийгээгүйгээс 387,272.2 мянган төгрөгийн ашиглалтын хугацаа дууссан, Эрүүл мэндийн яамнаас 2021-2022 онд үнэ төлбөргүй шилжүүлсэн 2,878,351.5 мянган төгрөгийн хугацаа дууссан оношлуур нийт 3,265,623.8 мянган төгрөгийн оношлуур урвалжийг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Ерөнхий захирлын 2023 оны 5 дугаар сарын 5 өдрийн А/94 тоот тушаалаар өмч хамгаалах байнгын комиссын протокол үйлдээгүй, санхүүгийн албанд мэдэгдээгүй, устгалтын компанитай гэрээ хэлцэл хийлгүйгээр ажлын бус өдөр устгалтыг | 1 | 3,265,623.7 | | | 1 | 3,265,623.7 | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| хийсэн байна. Мөн байгууллагын санхүүгийн албанд устгалт хийсэн бичиг баримт, эмч хамгаалах зөвлөлийн протокол, устгал хийсэн компанитай хийсэн гэрээг устгал хийснээс 10 хоногийн дараа нөхөн бүрдүүлж өгсөн байна. | | | | | | | | | | | | | |
| **Дүн** | **4** | **3,270,573.7** | **1** | **4,950.0** | **1** | **3,265,623.7** | **2** | **-** | | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| *Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил* | | | | | | |
| Шилэн дансны цахим системд аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, дараа жилийн төсвийн төслийн мэдээллийг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна. | 1 | - | | | 1 | - |
| **Дүн** | **1** | **-** | | | **1** | |
| *Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил* | | | | | | |
| Төлөөлөн удирдах зөвлөлд ажиллах олон нийтийн төлөөллийг сонгон шалгаруулаагүйгээс хяналтын тогтолцоо алдагдах эрсдэл үүссэн. | 1 | - | 1 | - | | |
| **Дүн** | **1** | **-** | **1** | **-** | | |



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 01 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

2024 он 02 сарын 29 № 67/А0150092 Улаанбаатар хот

СМАГ-2024/17/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант жилд Меджей ХХК-аас худалдан авах гэрээний дагуу нэг бүрийн үнэ нь 195,000.00 (нэг зуун ерэн таван мянга) төгрөгийн үнэтэй 400 ширхэг цээжний шингэн цуглуулах сав авахаас 165 ширхэг савыг гэрээний үнээс илүү үнээр буюу нэгжийн үнийг 225,000.00 (хоёр зуун хорин таван мянга) төгрөгөөр тус байгууллагад 4,950,000.00 (дөрвөн сая есөн зуун тавин мянга) төгрөгийг илүү төлсөн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6."Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна"; Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2 "Тендерийн хавтаст хэрэг дараахь баримт бичиг, материалаас бүрдэнэ:.. 49.2.10. гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан баримт бичиг... " гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.5-д " бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Гэрээний үнээс илүү үнээр авсан материалын 4,950,000.00 (Дөрвөн сая есөн зуун тавин мянга) төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Ерөнхий захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгч /Ж.Байгалмаа/, Санхүү албаны дарга, ерөнхий нягтлан бодогч /Г.Хунзаяа/ нарт даалгав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Ц.ХОСЖАРГАЛ
БАЯН ТАШААГИЙН ЭХ АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ Т.ХОРОЛСҮРЭН

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261230*

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 дугаар сарын 29 № 384/А0/50055 Улаанбаатар хот
СААГ-2024/17/ИА-СТА-Т245

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын дансанд Ковидоос бусад халдварт өвчнийг оношлох 2018-2019 онд худалдаж авсан оношлуурыг Ковидын улмаас 2021 оны 7 дугаар сар хүртэл амбулаториор өвчтөнүүдийг хүлээн авч үзлэг хийгээгүйгээс 387,272,264.00 (*Гурван зуун наян долоон сая хоёр зуун далан хоёр мянга хоёр зуун жаран дөрвөн)* төгрөгийн ашиглалтын хугацаа дууссан, Эрүүл мэндийн яамнаас 2021-2022 онд үнэ төлбөргүй шилжүүлсэн 2,878,351,500.00 *(Хоёр тэрбум найман зуун далан найман сая гурван зуун тавин нэгэн мянга таван зуун)* төгрөгийн хугацаа дууссан оношлуур нийт 3,265,623,764.00 (*Гурван тэрбум хоёр зуун жаран таван сая зургаан зуун хорин гурван мянга долоон зуун жаран дөрвөн*) төгрөгийн оношлуур урвалжийг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Ерөнхий захирлын 2023 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн А/94 тоот тушаалаар өмч хамгаалах байнгын комиссын протокол үйлдээгүй, санхүүгийн албанд мэдэгдээгүй, устгалтын компанитай гэрээ хэлцэл хийлгүйгээр ажлын бус өдөр устгалтыг хийсэн байна. Мөн байгууллагын санхүүгийн албанд устгалт хийсэн бичиг баримт, өмч хамгаалах зөвлөлийн протокол, устгал хийсэн компанитай хийсэн гэрээг устгал хийснээс 10 хоногийн дараа нөхөн бүрдүүлж өгсөн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", 67.2-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна", Төсвийн тухай хуулийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264330*

1 Эм эмнэлгийн хэрэгслийг устгахдаа устгалын компанитай гэрээ хийгээгүй, өмч хамгаалах комиссын хурлын шийдвэр, устгал хийсэн акт зэргийг цаг тухайд нь үйлдээгүй, нөхөн үйлдсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Ерөнхий захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгч /Ж.Байгалмаа/, Санхүү албаны дарга, ерөнхий нягтлан бодогч /Г.Хунзаяа/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Ц.ХОСЖАРГАЛ
БАЯН ТАШААГИЙН ЭХ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Т.ХОРОЛСҮРЭН

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 дугаар сарын 29 № 385/А0150055 Улаанбаатар хот

СПА(-2024/17/НА-СТА-ТШ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Төлөөлөн удирдах зөвлөлд ажиллах олон нийтийн төлөөллийг сонгон шалгаруулаагүйгээс хяналтын тогтолцоо алдагдах эрсдэл үүссэн.

Энэ нь Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4-т "Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, энэ хуулийн 16.10-т заасан суман дахь нэгдсэн эмнэлгээс бусад нэгдсэн эмнэлгийн удирдлагыг эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөл, түүнээс томилсон гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлнэ", 17.7-д "Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөл нь өмчлөгчийг төлөөлөх гурван гишүүн, тухайн эмнэлгийн хамт олныг төлөөлөх гурван гишүүн, олон нийтийг төлөөлөх гурван гишүүнтэй байна" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг бүрэн томилоогүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Ерөнхий захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгч /Ж.Байгалмаа/, Санхүү албаны дарга, ерөнхий нягтлан бодогч /Г.Хунзаяа/ нарт даалгав

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР — Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР — Ц.ХОСЖАРГАЛ
БАЯН ТАШААГИЙН ЭХ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ — Т.ХОРОЛСҮРЭН

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264430*